



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮ, ИРГЭНИЙ
ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ**

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 2023/ШЗТ/01

Сайншанд сум

Эрүү, Иргэн, Зөрчлийн хэргийн шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох, хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох нарийвчилсан журмыг батлах тухай

Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнийг Ерөнхий шүүгч Н.Батчимэг удирдан, шүүгч Н.Болормаа, шүүгч А.Сайнтөгс нарыг оролцуулан хийж, Эрүү, Иргэн, Зөрчлийн хэргийн шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох, хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох нарийвчилсан журмыг батлах тухай асуудлыг тус тус хянан хэлэлцээд Монгол Улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.1, 16.1.4, 17 дугаар зүйлийн 17.1.3, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2.2, 19.2.5, 19.3, 19.8, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 7, 38.4 дүгээр зүйлийн 2, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2, 8.2 дугаар зүйлийн 9, 9.2 дугаар зүйлийн 14, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 78 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1, 166 дугаар зүйлийн 166.3, Нийт шүүгчдийн чуулганы 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам"-ыг тус тус удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг нэгдсэн системээс урьдчилан мэдэх боломжгүй, тойрог дотор санамсаргүй тохиолдлоор байх зарчмыг баримтлан, хэргийг хуваарилахдаа "Ердийн журмаар хуваарилах арга", "Ачаалал тэнцүүлж хэрэг хуваарилах арга"-ыг тус тус ашиглахаар тогтсугай.
2. Эрүү, Иргэн, Зөрчлийн хэргийг Ерөнхий шүүгч Н.Батчимэг, шүүгч Н.Болормаа, шүүгч А.Сайнтөгс нарт хуваарилж, шүүх хуралдаанд илтгэхээр тогтоосугай.
3. Эрүү, Иргэн, Зөрчлийн хэргийг хүлээн авч шүүх хуралдаанд илтгэх шүүгчийн дарааллыг шүүгчдийн зөвлөгөөнөөр хийсэн сугалааг үндэслэн дор дурдсанаар тогтоосугай.
 - 3.1. А. Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системд;
 1. Шүүгч Н.Болормаа,

011100019

2. Ерөнхий шүүгч Н.Батчимэг,
3. Шүүгч А.Сайнтөгс,

Б. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны Иргэн-2014 нэгдсэн системд;

1. Шүүгч Н.Болормаа,
2. Ерөнхий шүүгч Н.Батчимэг,
3. Шүүгч А.Сайнтөгс,

В. Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийн Зөрчлийн хэргийн бүртгэлд;

1. Шүүгч Н.Болормаа,
2. Ерөнхий шүүгч Н.Батчимэг,
3. Шүүгч А.Сайнтөгс,

3.2. Шүүгчдийн зөвлөгөөнөөр сугалаагаар тогтоосон энэхүү дарааллаар шүүгчдийн нэрсийг Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны Иргэн-2014 нэгдсэн системд тус тус байршуулахыг мэдээлэл технологийн мэргэжилтэнд даалгасугай.

4. Давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг даргалах болон хэргийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүний дарааллыг дор дурдсанаар тогтоосугай.

4.1. Эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг даргалах болон хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч. Үүнд:

1. Шүүгч Н.Болормаа,
2. Ерөнхий шүүгч Н.Батчимэг,
3. Шүүгч А.Сайнтөгс,

4. Хэргийг хянан хэлэлцэх шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5-д зааснаар болон адил шатны өөр шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс санамсаргүй байдлаар сонгогдож Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний албажуулснаар шүүх бүрэлдэхүүнд оролцуулахаар томилогдсон шүүгч.

4.2. Зөрчлийн хэргийн шүүх хуралдааныг даргалах болон хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч. Үүнд:

1. Шүүгч Н.Болормаа,
2. Ерөнхий шүүгч Н.Батчимэг,
3. Шүүгч А.Сайнтөгс,

4. Хэргийг хянан хэлэлцэх шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5-д зааснаар болон адил шатны өөр шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс санамсаргүй байдлаар сонгогдож Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын

тэргүүний албажуулснаар шүүх бүрэлдэхүүнд оролцуулахаар томилогдсон шүүгч.

4.3. Иргэний хэргийн шүүх хуралдааныг даргалах болон хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч, Үүнд:

1. Шүүгч Н.Болормаа,
2. Ерөнхий шүүгч Н.Батчимэг,
3. Шүүгч А.Сайнтөгс,
4. "Хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.6-д заасны дагуу тухай бүр адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөж, "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5-д зааснаар болон тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс санамсаргүй байдлаар сонгогдсоноор тус шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар албажуулж шүүх бүрэлдэхүүнд оролцуулахаар томилогдсон шүүгч.
5. "Эрүү болон зөрчлийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах шүүгчид хуваарилах журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Иргэний хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах шүүгчид хуваарилах журам"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
6. Шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн, хэргийг шүүх хуралдаанд илтгэх шүүгчийг "Эрүү болон зөрчлийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах шүүгчид хуваарилах журам", "Иргэний хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах шүүгчид хуваарилах журам"-д зааснаар болон шүүгчдийн зөвлөгөөний энэхүү тогтоолоор тогтоосон дарааллын дагуу Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны Иргэн-2014 нэгдсэн системээс хуваарилсныг Монгол Улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий шүүгч захирамж гаргаж албажуулж байсугай.
7. Адил шатны өөр шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон шалтгаанаар шүүгч томилолтоор ажиллах шаардлага гарсан тохиолдолд шүүгчдээс урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор программаас сонгогдсон, эсхүл программ ажиллаагүйгээс программаас сонгогдох боломжгүй тохиолдолд тухай бүр шүүгчдийн зөвлөгөөнөөс тохиолдлын журмаар сугалаагаар сонгогдсон шүүгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулж байхаар тогтсугай.
8. "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам"-ын 2.4-т зааснаар хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн томилох үйлдэл бүрийг дүрс бичлэг хийж 7 хоног бүр хадгалах төхөөрөмжид (CD, DVD, флаш диск, хард диск гэх мэт) хуулбарлан хадгалах ба түүнд тогтмол хяналт тавьж ажиллахыг шүүхийн тамгын газрын дарга /С.Бурмаа/-д, журмын энэхүү заалтыг хэрэгжүүлж ажиллахыг шүүгчийн туслах /А.Баяржаргал/-д тус тус даалгасугай.
9. Энэхүү тогтоолыг мөн өдрөөс эхлэн хэлэлцсэн асуудлаар дараагийн тогтоол гарах хүртэл хүчин төгөлдөр үйлчлэхээр тогтоосугай.

10. Энэхүү тогтоолоор баталсан журмыг нэгдсэн системд тохируулахдаа шүүхийн тамгын газрын дарга, хэргийн хөдөлгөөн хариуцсан ажилтан, ерөнхий шүүгчийн туслах нарын хяналтын дор тохируулахыг мэдээлэл технологийн мэргэжилтэнд даалгасугай.
11. Уг тогтоолын биелэлтийг зохион байгуулж ажиллахыг Ерөнхий шүүгч /Н.Батчимэг/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ



Н.БАТЧИМЭГ

ШҮҮГЧИД




Н.БОЛОРМАА



А.САЙНТӨГС





ЭРҮҮ БОЛОН ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ШҮҮГЧИД ХУВААРИЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шүүхэд эрүүгийн болон зөрчлийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шүүгчид хуваарилахдаа Шүүхийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон Эрүүгийн хэргийн хөдөлгөөний стандартыг баримтлан Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем /цаашид систем/ гэх/-ээр хуваарилахдаа энэхүү журмыг баримтална.

1.2. Шүүхэд хүлээн авч байгаа эрүү, зөрчлийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг нэгдсэн системээс хуваарилж, шүүгчийн туслах ажлын цагт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шалгаж, ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авч, шүүгчээр гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

Хоёр. Хэрэг хуваарилах арга сонгох

2.1. Шүүхэд ирсэн эрүүгийн хэрэг болон зөрчлийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системээс "урьдчилан мэдэх боломжгүй", "тойрог дотор санамсаргүй тохиолдлоор сонгогдох" зарчмыг баримталж "Ердийн арга" болон "Ачаалал тэнцүүлж хэрэг хуваарилах арга" буюу "тус шүүхэд ирсэн 2-оос дээш хавтастай, 2-оос дээш шүүгдэгчтэй хэргийг ачаалал тэнцвэржүүлэх" аргыг сонгож хуваарилна.

2.2. Хэрэг хуваарилах журамд заасны дагуу буюу энэхүү журмын 2.1-д зааснаар хуваарилсныг шүүгчийн туслах шүүгчид хүлээлгэж өгнө.

2.3. Хяналтын шатны шүүхээс дахин шийдвэрлүүлэхээр ирүүлсэн хэргийг журмын 2.2-д заасны дагуу хуваарилна.

2.4. Хяналтын шатны шүүхээс өөр бүрэлдэхүүнтэйгээр дахин шийдвэрлүүлэхээр ирүүлсэн хэрэг, шүүх бүрэлдэхүүнд дахин оролцож болохгүй нөхцөл байдал үүссэн хэргийг системээс хуваарилсны дараа очих ёсгүй шүүгчид хуваарилагдсан бол системд тайлбар бичиж дахин хуваарилалтад оруулахдаа системийн шүүгчийг алгасах товчийг хэрэглэж журмын 2.1, 2.2-д заасан зарчмыг баримталж хуваарилна.

2.5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.1 дүгээр зүйлийн 2, 15.2 дугаар зүйлийн 4, 15.8 дугаар зүйлийн 1, 2-т заасны дагуу анхан шатны журмаар хэрэг

хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг журмын 2.1, 2.2-т заасны дагуу шүүгчид хуваарилна.

2.6. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хэрэгт холбогдуулан гаргасан гомдол, хүсэлтийг болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг журмын 2.1, 2.2-т заасны дагуу анх хэргийг шүүх хуралдаанд илтгэхээр хүлээн авсан шүүгчид хуваарилна.

2.7. Харьяалал тогтоож ирүүлсэн, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шийдвэр, тогтоол нь хүчингүй болсон хэргийг журмын 2.1, 2.2-д заасны дагуу шүүгчид хуваарилна.

2.8. Шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлт гаргасан, шүүгч татгалзан гарах хүсэлт гаргасан тохиолдолд татгалзлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд энэ үндэслэлээр хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэснээс хэргийг дахин хуваарилах нөхцөл үүсвэл бусад шүүгчид энэхүү журмын 2.1, 2.2-т заасан зарчим, аргыг баримтлан системээс хэргийг хуваарилна. Харин шүүгчийг татгалзан гаргаснаар шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу тухай бүр "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5-д зааснаар болон адил шатны өөр шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс санамсаргүй байдлаар сонгогдож томилогдсон шүүгчийг Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний албажуулснаар шүүх бүрэлдэхүүнд оролцуулна.

Гурав. Бусад

3.1. Шүүгч эрдэм шинжилгээний бүтээл туурвих, магистр, докторын болон бусад сургалтад хамрагдах, гурван сар болон түүнээс дээш хугацаагаар эмчлүүлэх зэрэг шалтгаанаар хуанлийн 30 хоногоос дээш хугацаагаар эзгүй байгаагаас бусад өвчтэй, чөлөөтэй, албан томилолттой, сургалтад хамрагдсан зэрэг тохиолдолд хэргийг шүүгчид журмын 2.1-д заасны дагуу хуваарилах бөгөөд энэ тохиолдолд хэрэг хуваарилах ажиллагааг зогсоохгүй.

3.2. Эрүүгийн хэргийн хувьд шүүгч түр эзгүй үед буюу өвчлөх, гачигдал гарах зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх бүрэлдэхүүнд оролцох боломжгүй болж шүүгч хүрэлцэхгүй болсон тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу тухай бүр "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5-д зааснаар болон адил шатны өөр шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс санамсаргүй байдлаар сонгогдож томилогдсон шүүгчийг Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний албажуулснаар шүүх бүрэлдэхүүнд оролцуулна.

3.3. Шүүгчид ээлжийн амралт эхлэхээс өмнө ажлын 10 хоногийн өмнө хэрэг хуваарилалтыг зогсоож, ээлжийн амралт эдэлж байгаа шүүгчид хэрэг хуваарилахгүй бөгөөд тухайн шүүгчид ажилдаа орсон эхний өдрөөс эхлэн хэрэг хуваарилах ба шүүгч ээлжийн амралттай байгаа үед ажиллаж байгаа бусад шүүгчид хэргийг журмын 2.1, 2.2-т заасны дагуу хуваарилна.

3.4. Шүүгч нар ээлжийн амралтыг зэрэг эдэлж байгаа болон ээлжилж амарсан боловч ээлжийн амралтын хугацаа давхацсан тохиолдолд энэхүү журмын 3.3-т заасан журмыг хэрэглэхгүй буюу системээс хэрэг хуваарилах ажиллагааг зогсоохгүй ба аль түрүүлж ажилдаа орох шүүгчид журмын 2.1, 2.2-т заасны дагуу хэргийг хуваарилна.

3.5. Журмын 3.3-т зааснаар хэрэг хуваарилах ажиллагааг зогсоосон тохиолдолд шүүгчийг ээлжийн амралт эдлээд ажилдаа орсон эхний өдрөөс эхлэн хэрэг хуваарилна.

3.6. Шүүгчдийн ажилласан жилээс шалтгаалж ээлжийн амралтын хугацаа урт, богино харилцан адилгүй байдгаас шалтгаалж шүүгчдийн шийдсэн хэргийн тоо харилцан адилгүй болсон үед "Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем"-ийн алгасах товч ашиглаж, тайлбар, үндэслэлийг бичиж ачааллыг тэнцүүлнэ.


3.7. Шүүгчид хэрэг хуваарилагдсаны дараа өвчлөх, гачигдал гарах зэрэг гэнэтийн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас нэгэнт товлогдсон шүүх хуралдаанд хүлээн авсан хэргийг илтгэх боломжгүй болсон тохиолдолд түүнд өмнө нь хуваарилагдсан байсан хэргийг бусад шүүгчид системээс журмын 2.1, 2.2-т заасны дагуу хуваарилж, цаашид дээрх шалтгаанаар 10-аас дээш хоногийн хугацаанд эзгүй байх тохиолдолд тухайн шүүгчид хэрэг хуваарилах ажиллагааг зогсооно.

3.8. Шүүх хуралдаанд хэрэг илтгэж байгаагаас бусад тохиолдолд Эрүү, Зөрчлийн хэргийн бүх шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч даргалах бөгөөд түүний эзгүйд болон Ерөнхий шүүгч хэргийг шүүх хуралдаанд илтгэж танилцуулж байгаа тохиолдолд үлдсэн шүүгчид тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2-т заасан дарааллаар шүүх хуралдаан товлогдсон өдөр өдрөөр ээлжлэн шүүх хуралдааныг даргална. Шүүх хуралдаан даргалахаар тогтоогдсон шүүгч эзгүй тохиолдолд тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2-т заасан дарааллыг баримтлан хэргийг шүүх хуралдаанд илтгэж танилцуулж байгаа шүүгчийн нөгөө шүүгч шүүх хуралдааныг даргална.

3.9. Ерөнхий шүүгчид тогтоол болон журамд заасны дагуу хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН

Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж
заалдах шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний
2023/ШЗТ/01 дүгээр тогтоолын хавсралт-2



ИРГЭНИЙ ХЭРЭГ, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ШҮҮГЧИД ХУВААРИЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Шүүхэд өргөдөл, гомдол, хүсэлт, хэрэг хүлээн авах, шүүгчид хуваарилахдаа Шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид ИХШХШтХ гэх/ болон Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлалыг баримтлан Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны Иргэн-2014 /Цаашид нэгдсэн систем гэх/ нэгдсэн системээр хуваарилахдаа энэхүү журмыг баримтална.

1.2 Давж заалдах шатны шүүхэд анхан шатны шүүхээс ирсэн хэргийг Иргэн-2014 нэгдсэн системээс хуваарилж, шүүгчийн нэрийг давж заалдах шатны шүүхэд хэрэг хүлээн авсан болон шүүгчид хуваарилсан бүртгэлд гараар бичиж, давж заалдах шатны шүүхэд хэрэг хүлээн авсан бүртгэл, гомдол хүсэлт хүлээн авсан тухай хэргийн дансанд шүүгчээр гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

Хоёр. Хэрэг хуваарилах арга сонгох

2.1 Давж заалдах гомдолтой хэрэг, арбитрын хэрэг, хяналтын шатны шүүхээр хянагдаад хүчингүй болж дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн хэрэг, адил шатны шүүхээс шилжиж ирсэн хэрэг тус бүрийг системээс урьдчилан мэдэх боломжгүй, тойрог дотор санамсаргүй тохиолдлоор сонгогдох зарчмыг баримтлан хэргийг хуваарилахдаа "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам"-д заасан "Ердийн журмаар хуваарилах арга", "Ачаалал тэнцүүлж хэрэг хуваарилах арга"-ыг тус тус ашиглана.

2.2 Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэр, магадлалыг дахин хянуулах тухай хүсэлтийг шүүгчид тогтоолын 3.1.6-д заасан дарааллаар системээс журмын 2.1-д заасан аргаар хуваарилна.

2.3 Шүүгчийг татгалзсан, шүүгч өөрөө татгалзан гарах хүсэлт гаргасан тохиолдолд татгалзлыг хуульд заасны дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэснээр шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй болж хэргийг шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.6-д заасны дагуу тухай бүр адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөж, "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах,

хуваарилах, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5-д зааснаар болон тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс санамсаргүй байдлаар сонгогдож томилогдсон шүүгчийг тус шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар албажуулснаар шүүх бүрэлдэхүүнд оролцуулна.

2.4 Бүрэлдэхүүний бүх шүүгчийг татгалзан гаргаснаар болон эсхүл бүх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахин оролцож болохгүй үндэслэл бий болсон тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2-т заасны дагуу хэргийг шилжүүлнэ. Бүх шүүгч гэдгийг тогтоолын 3.16, 4.3-д зааснаар хэрэг хүлээн авч шүүх хуралдаанд илтгэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг ойлгохоос гадна шүүгчийг дагнан ажиллуулах, ажлын ачаалал тэнцвэржүүлэх зорилгоор Иргэн-2014 нэгдсэн системд хэргийг хүлээн авч илтгэхээр зөвхөн нэг шүүгчийн нэрийг байршуулж тойрог үүсгэсэн тохиолдолд тухайн шүүгчийг бүх шүүгч гэж үзнэ.

Гурав. Бусад

3.1 Шүүгч эрдэм шинжилгээний бүтээл туурвих, магистр, докторын болон бусад сургалтад хамрагдах, гурван сар болон түүнээс дээш хугацаагаар эмчлүүлэх зэрэг шалтгаанаар хуанлийн 30 хоногоос дээш хугацаагаар эзгүй байгаагаас бусад өвчтэй, чөлөөтэй, албан томилолттой, сургалтад хамрагдсан зэрэг тохиолдолд хэргийг шүүгчид журмын 2.1-д заасны дагуу хуваарилах бөгөөд энэ тохиолдолд хэрэг хуваарилах ажиллагааг зогсоохгүй.

3.2 Шүүх хуралдаанд хэрэг илтгэж байгаагаас бусад тохиолдолд иргэний хэргийн бүх шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч даргалах бөгөөд түүний эзгүйд болон Ерөнхий шүүгч хэргийг шүүх хуралдаанд илтгэж танилцуулж байгаа тохиолдолд үлдсэн шүүгчид тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан дарааллаар шүүх хуралдаан товлогдсон өдөр өдрөөр ээлжлэн шүүх хуралдааныг даргална. Шүүх хуралдаан даргалахаар тогтоогдсон шүүгч эзгүй тохиолдолд тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан дарааллыг баримтлан хэргийг шүүх хуралдаанд илтгэж танилцуулж байгаа шүүгчийн нөгөө шүүгч шүүх хуралдааныг даргална.

3.3 Шүүгч түр эзгүй үед буюу өвчлөх, гачигдал гарах зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч хүрэлцэхгүй тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.6-д заасны дагуу тухай бүр адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөж, "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5-д зааснаар болон тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс санамсаргүй байдлаар сонгогдож томилогдсон шүүгчийг тус шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар албажуулснаар шүүх бүрэлдэхүүнд оролцуулна.

3.4 Шүүх бүрэлдэхүүний олонх буюу 2 нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.6-д заасны дагуу адил шатны өөр шүүхийн шүүгч бол хэргийг илтгэж байгаа тухайн шүүхийн шүүгч шүүх хуралдааныг өөрөө даргална.

3.5 Шүүгчид ээлжийн амралт эхлэхээс ажлын 10 хоногийн өмнө хэрэг хуваарилалтыг зогсоож, ээлжийн амралт эдэлж байгаа шүүгчид хэрэг хуваарилахгүй бөгөөд ажиллаж байгаа шүүгчид хэргийг журмын 2.1-т заасны дагуу хуваарилна.

3.6. Шүүгчдийг дагнан ажиллуулах зорилгоор хэргийг зөвхөн нэг шүүгч шүүх хуралдаанд илтгэхээр хүлээн авдаг бол түүний ээлжийн амралттай үед түүнд хэрэг хуваарилахыг зогсоохгүй.

3.7. Энэхүү 3.4-т заасан журам нь шүүгч нар ээлжийн амралтыг зэрэг эдэлж байгаа тохиолдолд хамаарахгүй ба энэ тохиолдолд журмын 2.1-т заасны дагуу хэрэг хуваарилах ажиллагааг зогсоохгүй. Шүүгч нар ээлжилж амарсан боловч амралтын хугацаа давхацсан тохиолдолд аль түрүүлж ажилдаа орох шүүгчид журмын 2.1-т заасны дагуу хэргийг хуваарилна.

3.8. Журмын 3.5-т зааснаар хэрэг хуваарилах ажиллагааг зогсоосон тохиолдолд шүүгчийг ээлжийн амралт эдлээд ажилдаа орсон эхний өдрөөс эхлэн хэрэг хуваарилна.

3.9. Шүүгчид хэрэг хуваарилагдсаны дараа өвчлөх, гачигдал гарах зэрэг гэнэтийн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас нэгэнт товлогдсон шүүх хуралдаанд хүлээн авсан хэргийг илтгэх боломжгүй болсон тохиолдолд түүнд өмнө нь хуваарилагдсан байсан хэргийг бусад шүүгчид системээс журмын 2.1-т заасны дагуу хуваарилж, цаашид дээрх шалтгаанаар 10-аас дээш хоногийн хугацаанд эзгүй байх тохиолдолд тухайн шүүгчид хэрэг хуваарилах ажиллагааг зогсооно.

3.10. Ерөнхий шүүгчид тогтоол болон журамд заасны дагуу хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН